

ТӨЛБӨРИЙН КАРТЫН ХЭРЭГЛЭЭ



Бэлэн мөнгөний эрсдлээс ангижрах үүднээс иргэд ихэвчлэн төлбөрийн карт хэрэглэж байна.


2.3
сая

2015 оны эцсийн байдлаар Монгол Улсад **2,3 сая ширхэг төлбөрийн карт** идэвхтэй ашиглагдаж байна.



Картын хэрэглэгчид ATM төхөөрөмж ашиглан жилд 117 сая ширхэг гүйлгээ буюу **өдөрт дунджаар 320 мянган гүйлгээ** хийж байна.

ATM төхөөрөмжөөр хийгдсэн картын гүйлгээ



Тэгвэл банкны карт эзэмшигчид ATM төхөөрөмжөөр гүйлгээ хийхэд хэдэн төгрөгний шимтгэл төлж байна вэ?

Арилжааны ихэнх банкууд ATM төхөөрөмжөөр үйлчлүүлэхэд дараах шимтгэлийг авч байна.

Бэлэн мөнгө авах	Үйлчилгээний шимтгэл
Өөрийн банкны ATM-ээс	100 төгрөг
Гэрээт банкны ATM-ээс	300 төгрөг
Бусад банкны ATM-ээс	500 төгрөг

Карт эзэмшигчид зөвхөн өөрийн банкны ATM төхөөрөмжөөс бэлэн мөнгө авдаг гэж тооцвол,

Жилд **11,7 тэрбум төгрөг**

Өдөрт **32 сая төгрөгийн**

үйлчилгээний шимтгэл төлж байна.

ИНТЕРНЕТ БАНКНЫ ХЭРЭГЛЭЭ




2015 оны эцсийн байдлаар интернет банкны эрхтэй **126 мянган идэвхтэй хэрэглэгч** байна.




Мобайл хандалтын эрхтэй **876 мянган идэвхтэй хэрэглэгч** байна.

Интернет гүйлгээний тоо, 4У'15



Интернет гүйлгээний дүн, 4У'15



Мобайл гүйлгээ, 4У'15

6,2 сая ширхэг

1 290 тэрбум төгрөг

БАНКУУДЫН ӨРСӨЛДӨӨНИЙ ТОЙМ

2015 он – IV улирал

Банкны салбарын актив, их наяд төгрөг




Салбарын нийт актив 2015 оны эцсийн байдлаар 21 их наяд төгрөг байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 5% буурсан өмнөх улирлаас 1% нэмэгдсэн үзүүлэлт юм.

Нийт активын бүтэц, 4У'15




Нийт зээл, их наяд төгрөг




Нийт зээлийн дүн 11 их наяд төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 6%, өмнөх улирлаас 2% тус тус буураад байна. Зээлийн жилийн өсөлтийн хурд сүүлийн 3 улирал дараалан хасах утгатай гарлаа. 2015 оны эцсийн байдлаар чанаргүй зээлийн хувь 5,5% болж өсөөд байна.

Ипотекийн зээл, их наяд төгрөг



Өөрөөр хэлбэл зээл олголт, активын чанарын үзүүлэлт өнгөрсөн онтой харьцуулахад харьцангуй сул байна.

Чанаргүй зээл, тэрбум төгрөг




Оны эцсээр иргэний болон үл хөдлөх хөрөнгийн тухай хуулийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн гэсэн Цэцийн дүгнэлт гарсантай холбоотойгоор арилжааны банкууд ипотекийн зээлээ түр хугацаанд зогсоосон, шинэ он гарсаар эргээд хэвийн олгож эхэлсэн болон тодорхой байршлуудад ипотекийн зээлийг 5 хувийн хүүтэй олгож эхэлсэн зэрэг үйл явдлууд банкны болоод барилгын салбарт цочрол өгсөн мэдээллүүд байлаа.

Манай улсын эдийн засагт банкны салбар томоохон үүрэг гүйцэтгэдэг, бараг иргэн бүр банкны зээл, тэр дундаа ипотекийн зээлээс хамааралтай байгаа нь эргээд банк болон барилгын салбарт гарч буй шийдвэрүүд эдийн засгийн гэхээсээ илүү улс төрийн агуулгатай болох эрсдэл дагуулж байна.


БАНКУУДЫН ӨРСӨЛДӨӨНИЙ ТОЙМ

2015 он – IV улирал


Хадгаламж ба харилцах, их наяд төгрөг




Зээл ба хадгаламж, харилцахын харьцаа



Өөрийн хөрөнгө, их наяд төгрөг




Хүүний динамик, төгрөгийн



Банкуудын татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн дүн мөн өнгөрсөн оноос буурсан үзүүлэлттэй байна. Нийт харилцах ба хадгаламж 9.5 их наяд төгрөг хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үеэс 5% буураад байгаа юм.

Хадгаламжийн бүтэц, 4У'15



Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд зааснаар 2016 он хүртэл 100 сая төгрөгөөс бага дүнтэй хадгаламжийн хүүний орлогыг татвараас чөлөөлж байсан бол үүнийг 2018 он хүртэл болгон сунгаад байна. Өөрөөр хэлбэл одоогийн хуулиар 2018 он хүртэл 100 сая төгрөгөөс бага дүнтэй хадгаламжийн хүүний орлогоос татвар авахгүй юм.

Хадгаламжийн хүүний орлогоос татвар авдаг болгох эрхзүйн орчныг бүрдүүлж байгаа ч одоогоор эдийн засгийн нөхцөл байдлаас хамааран хараахан бэлэн биш байна гэж үзэж байна.

Түүнээс гадна манай улсын нийт хадгаламжийн ихээхэн хэсгийн цөөн тооны хадгаламж эзэмшигчид бүрдүүлдэг гэсэн албан ёсны бус мэдээ байдаг.

Хадгаламж болон зээлийн хүүний зөрүү буюу зуучлалын зөрүү 6% байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 нэгж хувиар буурсан байна.

Инфляцийн түвшин зорилтот түвшнээс доогуур байгаатай уялдан Монголбанк бодлогын хүүг 1 хувь бууруулан 12% болгох шийдвэр гаргасан ба 2016 оны 1 сарын дундуур хэрэгжиж эхлээд байна.

Мөнгөний бодлогыг сулруулж буй энэхүү шийдвэр нь урт хугацаанд банкны зээлийн хүү буурах хүлээлтийг бий болгож байна.

Банкны салбарын үндсэн үзүүлэлтүүд, улирлын өсөлт, хувь

	2013		2014				2015				IV
	III	IV	I	II	III	IV	I	II	III		
Активын өсөлт	13.9%	14.8%	(0.8%)	3.4%	(2.2%)	7.9%	(8.0%)	5.2%	(2.4%)	1,0	
Зээлийн өсөлт	18.1%	3.1%	5.9%	8.9%	2.6%	(0.9%)	(1.9%)	(2.7%)	(0.1%)	(2,0)	
Ипотекийн зээлийн өсөлт	56.1%	20.3%	13.1%	11.2%	7.3%	8.6%	6.0%	5.8%	4.0%	3,4	
Чанаргүй зээлийн хувь	5.3%	2.5%	2.6%	2.7%	2.8%	3.1%	3.9%	4.6%	5.1%	5,5	
Харилцахын өсөлт	8.4%	(3.0%)	(10.8%)	8.1%	7.0%	7.5%	(22.3%)	7.3%	(2.2%)	(1,8)	
Хадгаламжийн өсөлт	5.6%	20.0%	12.5%	(0.8%)	(2.3%)	5.9%	(0.1%)	(0.9%)	(0.4%)	1,5	
Өөрийн хөрөнгийн өсөлт	6.2%	9.3%	41.7%	6.5%	5.4%	10.9%	2.1%	4.7%	3.3%	2,1	

Банкны салбарын онцлох үйл явдлууд

11.11	“Монгол улсын эрсдэлийн удирдлагын форум - 2015” форум зохион байгуулагдлаа.
12.10	Иргэний болон үл хөдлөх хөрөнгийн тухай хуулийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн гэсэн Цэцийн дүгнэлт гарсантай холбоотойгоор арилжааны банкууд <i>ипотекийн найман хувийн хүүтэй зээл олголт</i> оо түр зогсоох шийдвэр гаргалаа.
01.14	Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл <i>мөнгөний бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж</i> 12 хувь болгох шийдвэр мөрдөгдөж эхэллээ.
01.19	УИХ-аас Иргэний хуульд нэмэлт оруулах тухай болон Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг батлав. Ингэснээр банкууд найман хувийн хүүтэй ипотекийн зээлийг олгож эхэлж байна.
03.15	Засгийн газраас <i>Орон сууцны ипотекийн таван хувийн хүүтэй зээл олгох</i> журмыг батлан эхний ээлжинд Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд хамрагдах орон сууц, алслагдсан дүүргүүд болох Багануур, Багахангай, Налайх, нийслэлийн шинэ суурьшлын бүс, 21 аймгийн нутаг дэвсгэрт байгаа орон сууцыг худалдан авах иргэдэд 5 хувийн ипотекийн зээл олгож эхэлсэн ба эдгээр байршилд баригдсан орон сууцны ипотекийн зээл авсан иргэдийн зээлийг 8 хувиас 5 хувийн хүүтэй ипотекийн зээл рүү шилжүүлж байна.

Банкуудын өрсөлдөөний тойм

Арилжааны банкны үндсэн үүрэг нь мөнгөн хөрөнгийн илүүдэлтэй байгаа хэсгээс хөрөнгийг татаж, дутагдалтай байгаа хэсэгт шилжүүлэн, харилцагчдын итгэл дээр суурилсан санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа үзүүлэх, харилцагчдын хоорондын төлбөр тооцоог хийж гүйцэтгэх бөгөөд эцсийн зорилго нь санхүүгийн үйлчилгээгээр дамжуулан ашиг олох явдал билээ.

2015 оны II улирлын байдлаар банкны салбарт нийт 14¹ арилжааны банк үйл ажиллагаа явуулж байна. Монголбанкны тодорхойлсноор системд нөлөө бүхий банкуудад Хаан банк, ХХБ, Голомт банк, Хасбанк, Төрийн банк, Улаанбаатар хотын банк гэсэн 6 банк багтаж байна. Эдгээр банкууд нь системийн 90-ээс дээш хувийг бүрдүүлж буй юм.

Арилжааны банкуудын санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, өөрчлөлт хөдөлгөөнийг харуулдаг мэдээллийн гол эх сурвалж бол банкуудын санхүүгийн тайлан юм. Банкуудын өрсөлдөөний тоймыг гаргахдаа санхүүгийн хураангуй тайланг ашиглан дараах үзүүлэлтүүдийг харьцуулсан болно.

Үүнд:

- Нийт актив
- Зээл
- Харилцах, хадгаламж
- Өөрийн хөрөнгө
- Ашиг

Түүнчлэн банкны үйл ажиллагааны үр дүнг илэрхийлэгч зарим нэг харьцаа, үзүүлэлтүүдийг тооцлоо.

Эдгээр үзүүлэлтээр арилжааны банкуудыг харьцуулахдаа активын хэмжээгээр нь Том-3 банк, Дунд-3 банк, жижиг банкууд гэж ангилсан.



АКТИВ

БАНКУУД


Төрөл	Хэмжээ	Банкууд
ТОМ-3 БАНК	>3 их наяд төгрөг	Худалдаа хөгжлийн банк Хаан банк Голомт банк
ДУНД-3 БАНК	1-3 их наяд төгрөг	Хасбанк Төрийн банк Улаанбаатар хотын банк
ЖИЖИГ БАНКУУД	<1 их наяд төгрөг	Капитал банк Чингис хаан банк Капитрон банк Үндэсний хөрөнгө оруулалтын банк Ариг банк Богд банк Кредит банк Тээвэр хөгжлийн банк

¹ Хадгаламж банк 2013 оны 7 сард Төрийн банктай нэгдсэн. Богд банк шинээр (2014 оны сүүлээр тусгай зөвшөөрлөө авсан) үүсгэн байгуулагдсан.

АКТИВ

Тайлант хугацаанд арилжааны банкуудын нийт активын² 70 хувь нь Том-3 банкинд, 25 хувь нь Дунд-3 банкинд төвлөрч байгаа бол Жижиг банкууд нийт активын 5 хувийг бүрдүүлж байна.

Зах зээлд эзлэх хувь, активаар, 4У'15




Активын хэмжээгээр ХХБ зах зээлд тэргүүлж байгаа бол Хаан, Голомт банкууд удаалж байна.


Активын өсөлтийн хувьд ХХБ, Хаан банкууд эерэг дүнтэй байгаа бол бусад Том, Дунд банкууд буурсан үзүүлэлттэй байна.

Жижиг банкуудын хувьд активын өсөлтийн хурд харьцангуй өндөр байна.


Том-3 банк



Дунд-3 банк



Жижиг банкууд




² Арилжааны банкуудын санхүүгийн хураангуй тайлангийн нийлбэр дүнгээр тооцов. Энэ удаагийн тайланд Чингис хаан, Капитрон, Тээвэр хөгжлийн банкны мэдээлэл ороогүй болно.

ЗЭЭЛ

Банкуудын нийт зээлийн³ 69 хувийг Том-3 банк, 24 хувийг Дунд-3 банк, үлдсэн 7 хувийг жижиг банкууд олгосон байна.

Зах зээлд эзлэх хувь, зээлээр, 4У'15




Том, Дунд банкуудын хувьд зээл олголт саарч байгаа нь ажиглагдаж байна. Харин Жижиг банкуудын хувьд зээлийн хэмжээ өнгөрсөн онтой харьцуулахад нэмэгдэж байна.


Голомт банкны зээлийн хэмжээ 18 хувь, Төрийн банкны зээлийн хэмжээ 14 хувь тус тус хумигдсан байна.

Харин Жижиг банкуудын зээлийн дүн 4-35 хувь нэмэгджээ.


Том-3 банк



Дунд-3 банк




Жижиг банкууд



³ Арилжааны банкуудын санхүүгийн хураангуй тайлангийн нийлбэр дүнгээр тооцов. Энэ удаагийн тайланд Чингис хаан, Капитрон, Тээвэр хөгжлийн банкны мэдээлэл ороогүй болно.

ХАРИЛЦАХ БА ХАДГАЛАМЖ

Нийт харилцах ба хадгаламжийн⁴ 69 хувийг Том-3 банк, 25 хувийг Дунд-3 банк, үлдсэн 6 хувийг жижиг банкууд бүрдүүлж байна.



Эх үүсвэрийн хэмжээгээр Хаан банк тэргүүлж, ХХБ, Голомт банкууд удаалж байна.



Активын хэмжээгээр ХХБ тэргүүлж байсан бол зээл, харилцах хадгаламжийн дүнгээр Хаан банк тэргүүлж байгаа юм.

Ариг банк харилцах, хадгаламж татан төвлөрүүлсэн дүнгээ хамгийн ихээр буюу 64 хувь нэмэгдүүлсэн байна.


Том-3 банкуудаас ХХБ, Голомт, Дунд-3 банкаас Төрийн банк, УБХБ банкуудын харилцах, хадгаламж татан төвлөрүүлсэн дүн өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад буурч байна.

Том-3 банк

Дунд-3 банк



Жижиг банкууд



⁴ Арилжааны банкуудын санхүүгийн хураангуй тайлангийн нийлбэр дүнгээр тооцов. Энэ удаагийн тайланд Чингис хаан, Капитрон, Тээвэр хөгжлийн банкны мэдээлэл ороогүй болно.

ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

Банкуудын нийт өөрийн хөрөнгийн⁵ 75 хувь нь Том-3 банкинд, 19 хувь нь Дунд-3 банкинд, 6 хувь нь жижиг банкуудад байршиж байна.




Өөрийн хөрөнгийн хэмжээгээр ХХБ тэргүүлж байгаа бол өөрийн хөрөнгөө хамгийн их нэмэгдүүлсэн банк нь ҮХОБ байна.


Өнгөрсөн улиралтай харьцуулахад Хаан банк зах зээлд эзлэх хувиа 1.3 нэгж хувиар нэмэгдүүлсэн бол ХХБ-ны зах зээлд эзлэх хувь 1.1 нэгж буурсан нь хамгийн өндөр өсөлт ба бууралт байлаа.

Ариг банкны хувьд өөрийн хөрөнгийн өсөлт хасах утгатай байгаа бол бусад банкууд өнгөрсөн жилийн хугацаанд өөрийн хөрөнгөө тэлсэн үзүүлэлттэй байна.


Том-3 банк



Дунд-3 банк



Жижиг банкууд



⁵ Арилжааны банкуудын санхүүгийн хураангуй тайлангийн нийлбэр дүнгээр тооцов. Энэ удаагийн тайланд Чингис хаан, Капитрон, Тээвэр хөгжлийн банкны мэдээлэл ороогүй болно.

ХАРЬЦАА, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

[Зээл/Харилцах ба хадгаламж] харьцаа


Энэ харьцаа нь банкууд нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийнхөө хэдэн хувийг зээл болгон гаргаж буйг харуулна.

Хэт өндөр байвал эх үүсвэрийн дутагдалтай буюу дотоодын зах зээлээс татан төвлөрүүлсэн харилцах, хадгаламжийн дутагдалтай байх, зээлийн эрсдэл үүсэх, банкууд гадаад эх үүсвэрийг ихээхэн ашиглаж байгааг илтгэнэ. Бага байвал эх үүсвэрийн илүүдэл үүсэх, ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлөх магадлалтай.

Банкуудын дунджаар энэ харьцаа 105% байна.

Өөрөөр хэлбэл банкууд харилцах ба хадгаламжаас гадна бусад эх үүсвэрээр бүрдүүлсэн хөрөнгөөр зээл олгож байна.

Тайлант хугацаанд Хаан, Голомт, Төрийн банк, УБХБ, Ариг банкууд эх үүсвэрийн илүүдэлтэй байна.




[Хүүний зардал/Хүүний орлого] харьцаа

Банкуудын үр ашигтай үйл ажиллагааг хэмжих энэхүү үзүүлэлт нь хүүний орлогын хэдэн хувь нь зардал болон гарч буйг харуулна. Бага байвал үйл ажиллагааны зардал бага, ашиг өндөр байна гэж ойлгож болно.

Системийн нийт дүнгээр энэ үзүүлэлт 62% байна.

Тайлант хугацаанд Хасбанк зардлаа хамгийн их хувиар бууруулж чаджээ.



АШИГТ АЖИЛЛАГАА


Арилжааны банкуудын санхүүгийн тайлангийн нийлбэр дүнгээр⁶ банкууд 2015 оны IV улиралд нийт 242 тэрбум төгрөгийн ашигтай (татварын дараах) ажиллажээ.

Нийт өөрийн хөрөнгө 2.2 их наяд төгрөгт харьцуулбал тайлант улиралд өөрийн хөрөнгийн 100 төгрөг тутамд 11 төгрөгийн ашигтай ажилласан байна.


Тайлант хугацаанд Хас банк цэвэр ашгаа хамгийн ихээр нэмэгдүүлсэн байна. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд Хас банкны ашиг 11 тэрбум төгрөгөөр буюу бараг хоёр дахин өссөн амжилттай байна.

Хаан банкны ашиг 12 хувь нэмэгдсэн бол бусад Том, Дунд банкуудын ашгийн хэмжээ өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад буурч байна.


Том-3 банк



Дунд-3 банк



Жижиг банкууд



Эх үүсвэр:

Санхүүгийн болон Банкны салбарын тойм хэсэгт Монголбанк (2013 оны 4 дүгээр улирлаас хойш татан буугдсан банкуудын дүнг хассан статистикийг ашиглав), Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний статистикийн хорооны мэдээллийг ашиглав.

Банкуудын өрсөлдөөний тойм хэсэгт арилжааны банкуудын санхүүгийн хураангуй тайланг ашиглав.

Товчилсон нэрс:

4У'15 2015 оны 4 дүгээр улирал
ББСБ Банк бус санхүүгийн байгууллага
ГШХО Гадаадын шууд хөрөнгө оруулалт
ДНБ Дотоодын нийт бүтээгдэхүүн
ОСИСТБ Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр
УБХБ Улаанбаатар хотын банк
ҮХОБ Үндэсний хөрөнгө оруулалтын банк
ҮЦЗЗ Үнэт цаасны зах зээл
ХЗХ Хадгаламж, зээлийн хоршоо
ХХБ Худалдаа хөгжлийн банк

⁶ Арилжааны банкуудын санхүүгийн хураангуй тайлангийн нийлбэр дүнгээр тооцов. Энэ удаагийн тайланд Чингис хаан, Капитрон, Тээвэр хөгжлийн банкны мэдээлэл ороогүй болно.